

УДК 811.512.36

© **Баттуяа О.**

доктор Ph.D., старший преподаватель,
Мандах буртгэл их сургууль. Монголия
battuya_mgl@yahoo.com

МОНГОЛЫН ХАМНИГАНЫ ХЭЛ АЯЛГУУНЫ АСУУДАЛД

Аннотация. Монголд угсаатны 20 гаруй бүлэг байдгийн нэг нь хамниган юм. 2010 оны байдлаар хамниган хүн 537 гэж бүртгүүлсэн байна. Манай улсын хамниганы талаарх судалж хэвлүүлсэн зүйл ховор, 1961 онд гарсан академич Б.Ринченгийн “Монгол Ард Улсын хамниган аялгуу” (Б. Ринчен, “Монгол ард улсын хамниган аялгуу”, УБ, 1968) номноос өөр нэгэн сэдэвт бүтээл байхгүй байна. Монголын хамниганы судалгааны түүхээс харахад тэдний хэл аялгууг голлон судалж иржээ. Энэ илтгэлд Монголын хамниганы хэл аялгууны онцлог ба өнөөгийн хамниганы дунд хадгалагдсан зарим нэг үгийн гарал холбогдлыг хээрийн судалгааны материал болон хамниган хэл аялгууг судалсан монгол эрдэмтдийн санал дүгнэлтэд үндэслэн авч үзлээ.

Ключевые слова: хамниган; монголын хамниган; эвенг; дундад эртний монгол хэлний үлдэцтэй хамниган аялгуу; ерөөгийн хамниган; талайбун; гулбуун; олоч; аталга.

Battuya O.

Doctor Ph.D., st. prep.
Enroll at Mandakh University. Mongolia
battuya_mgl@yahoo.com

THE ISSUES OF SYNDROMIC LANGUAGES OF MONGOLIA

Abstract. There are more than 20 ethnic groups in Mongolia - Khannigans. As of 2010, the Haman was registered as 537. There is nothing short of published research on the khannig of our country, except for the book by Academician B. Rinchen in 1961, «The Khamannan Melody of the People's Republic of Mongolia» (B. Rinchen, UB, 1968). The history of Mongolian Hamnan studies has shown that they mainly study the language. The report examines the features of Mongolian Hamnan language and the origins of some of the words preserved in today's Hamnan, based on the field study material and the opinion of Mongolian scholars who have studied Haman language.

Keywords: hannigan; mongolian hannigan; eugen; melanian melody with medieval Mongolian language; marynian hannigan; talaybun; kangaroo; oloch; handkerchief.

Академич Б. Ринчен дорнод Монголын хамниган ба Сэцэн ханы хамниганы дунд 1940-өөд оноос хойш 20 гаруй жил судалгаа явуулж тэднийг 2 өөр хэл аялгуугаар ярьдгийг тодруулжээ. Тэр хоёр хэл аялгууны нэгийг нь эртний монгол хэлний шинж тэмдэгийг хадгалж монгол худам үсгээр бичсэнтэй яв цав нийлдэг “дундад эртний монгол хэлний үлдэцтэй хамниган аялгуу”, нөгөө нь “жинхэнэ хамниган” буюу “эвенг” хэл юм гэжээ. Бас Монголын хамнигад нь дундад эртний монгол хэлний аялгууг худам монгол бичгээр дамжуулан сурсан хэрэг огт биш, хамнигацуулын аманд үлдсэн монгол аман аялгууны зүйл, иймээс тэднийг хамниган хэлнээс монгол хэлэнд хэдийд орсныг гэрчилнэ гэсэн угсаа түүхийн холбогдолтой санаа ч бас хэлсэн байдаг.

Л. Мишиг зүүн хойд Монголын хамниганы дунд (Хэнтийн Дадал ба Биндэр суманд) явуулсан судалгааныхаа дүнд хамниганыг XIII–XIV зууны үеэс эхлэн монгол хэлээр ярих болсон бололтой, одоогийн хэл аялгуу нь “Монголын нууц товчоо”-ны хэл буюу дундад эртний монголчуудын хэлний онцлогийг хадгалсаар байх тул тэднийг дундад эртний монгол хэлээр яригчид гэж болно хэмээн Б. Ринчен аbugайтай санал нэгджээ. Тэрээр Монголын зүүн хойд нутгийн хамниганы аман хэл аялгууг дотор нь 1. Цамхаг, Балжхаан, Хярхун, Агуцын; 2. Берц, Хэр, Сүмэндийн; 3. Үзөөний гэж ялгасан байна [1]. Энд тэмдэглэсэн “үзөөн” гэдэг нь өнөөгийн хамниганы дундах овог юм. Үзөөн овгийнхныг ХҮП зууны сүүлээр болсон Халх ба Ойрадын дайны үеэр монгол нутгаас ойн гарч Байгал тийш очсон гэж буриадын сурвалжид тэмдэглэсэн нь бий. Монголын хамниганы дотроос үзөөний хэл аялгуу арай өөр байдгийг 2003–2004 онд хийсэн манай судалгааны үеэр ч гэсэн дорнод Монголын хамниган настангууд дурдаж “үзөөнүүд чинь биднийг (хамниганыг) бодвол үг хэл нь аальхан (намуун зөөлөн. — О.Б)” гэж байсан билээ. Бас үзөөнүүдийг хэл аялгуугаар төдийгүй нийтэд нь өөрсдөөсөө ялгаж үзэх хандлагатай үзөөнүүд л тэгдэг бид (хамнигад) тэгдэггүй гэх мэтээр ганц нэг ахуй соёлын ба нутагшлын онцлогийг хэлж байв [2].

Б. Ринченг судалгаа хийх үед Монголын хамниганы цөөн хэсэг нь эвенгээр ярьж, тэр эвенг хэлээ жинхэнэ хамниган хэл маань гэж “дундад эртний монгол хэлний үлдэцтэй хамниган аялгуу” — наасаа ялгаж үзэж байжээ¹. Б.Ринчен монгол хамниганы эвенг хэлний угсаа

¹ Ринчен Б. МАУ-ын хамниган аялгуу. Улан-Батор, 1969. Т. 88.

хэлзүйн холбогдлыг хэдэн шинжээр гаргасан байна. Монгол хамниганы ярьдаг байсан эвенг хэлний “к” гийгүүлэгч нь монгол хэлний ойрад монголын аялгуун дахь эм үгний “к” гийгүүлэгчтэй дуудлага ойролцоо. Бас “а”, “о” – той үгэнд ч мөн нэгэн адил орж, “кадум” [хадам, мон], “кола” [хол, мон] гэх мэтийн монгол хэлнээс орсон үгэнд оролцоно гэжээ. Монгол хамниган хэлний хэлний хойгуурх “н” гийгүүлэгчийг хэлний урдуурх “н”-тэй хутгаж болохгүй биеэ даасан авиалбар. Оросын хамниганы¹ олон хэлнээ энэ хэлний хойгуурхи “н” гийгүүлэгчийг “нг” хэмээн хэрэглэдэг журам нь хоёр өөр бөгөөд биеэ даасан авиалбар болохын хамт үгийн утга ялгаж өгдөг үүрэгтэйг тэмдэглэжээ. Тэрээр цааш нь нанай хэлнээ гарыг “нгала”, дансыг “дангса” гэх зэргээр бичдэг гэдгээр жишээ татаж монгол хамниганы хэлний нэгэн шинжийг нанайн хэлтэй харьцуулж монгол хамниганы эвенг хэлийн хамаадлыг тодотгосон байдаг.

Монголын хамниганы хэл аялгууг судалсан Л.Мишиг 1970-аад оны үед Ерөөгийн хамниганаас ая хогноори- эр хүн, эрүү хогноори-эм хүн, ая фагдаари- лам хүн[сайн] гэх хэдэн үг² олж тэмдэглэжээ. Б.Ринчен Л.Мишигийн олж мэдсэн эдгээр үгсийг зүүн зүгийн манж хэл соёлын нөлөөтэй солоон эвенг хэлнээс орж ирсэн гэж үзсэн байна. Ерөөгийн хамниганы хэлцэж байсан дээрх үгнүүд нь ХҮШ зууны үед “намиад”, “пөөинкин”-үүд Ерөөд байсныг, мөн Ерөөгийн хамнигад өндөр гэгээн Занабазарын үед жинхэнэ хамниган үгээрээ хэлэлцэж байсны нотолгоо гэжээ. Л. Мишиг Ерөөгийн хамниганаас гадна зүүн хойд Монголын хамниганы хэлийг судалсан байдаг. Тэрээр Зүүн хойд Монголын хамниганы хэлийг Баргужины хамниган, барга хамниган хэл, манж бичгийн хэлний язгуур нэгтэй үгстэй харьцуулаад 1. Монголын зүүн хойд нутгийн хамнигад нь манж хамниган (манж-түнгүүс) хэлтний нэг хэсэг 2. Тэндхийн хамниганы

¹ Ринчен Б. Зөвлөлтийн хамниганы олон хэл гэдэгтээ Зөвлөлтийн бүрэлдэхүүнд багтдаг манж-түнгүүсийн төрөл хэлтнүүдийг хамаатуулж хэлж байгаа юм. Түүний дурдсан бүтээлд // Монгол Ард Улсын хамниган хэл аялгуу. Улан-Батор, 1968) хамниган гэдгийг европ зүгийн хэлнээ түнгүүс гэж хэлдэг хэмээн тайлбарласан байдаг. Иймээс түүний хамниган гэж бичээд байгааг нь түнгүүс гэдгээ хэлж байна гэж ойлгох нь зүйтэй юм.

² ая гэдэг нь хамниганаар (эвенг-О. Б) “сайн” гэсэн үг. Харин “Хогноори” гэдэг нь солоон хамниганы “хонгнори”, Сэцэн ханы хамниганы “коннорин”, Баргужины хамниганы “конгномо” - хар гэсэн үг юм. Иймээс “ая когноори” гэж эр хүнийг “сайн хар”/хүн/ эм хүнийг “муу хар/хүн/” гэж нэрлэж байсан байнам. Ринчен Б. Монгол Ард Улсын хамниган хэл аялгуу. Улан-Батор, 1968.

хэл аялгуу нь хамниган эвенг хэлний өмнөд¹ буюу баруун салаанд багтах аялгуу байсан бололтой гэсэн санал хэлсэн байна.

Хэлний шинжээчдийн судалгаанаас үзэхүл Монголын аль ч нутгийн хамниган хэлцдэг нэг хэл нь эвенг байжээ гэдэг нь тодорхой байна. Эдүгээ Монголын хамниганы эвенг буюу жинхэнэ хамниган хэл нь хэдийн мартагдаж орхигдсон, 2003–2005 онд Хэнтий, Дорнод аймгийн хамниганы дунд явуулсан судалгааны үеэр ч эвенг хэлний талаар дурдсан хүн таараагүй билээ. Эвенг хэлийг бараг хэрэглэхээ больсон, жинхэнэ хамниган буюу эвенг хэлээ төсөөлдөг хүн их сайндаа л 50-иас хэтрэхгүй, тэднээс залгаад сурах хүн ч байхгүй тул жил ирэх тутам л хамниган(эвенг) үгээ мэдэгчид цөөрсөөр байна гэж Б.Ринченгийн дүгнэн тэмдэглэсэн нь биелэлээ олсон нь энэ бололтой. Харин өөрийгөө халх гэдэг Хэнтийн Цэнхэрмандалын хамниган хүн намайг багад (1980-аад оны үе) бидний эмэг эхийн үеийн хэдэн хөгшцүүл цуглаад хачин ойлгогдохгүй хэлээр ярьдаг байсан. Бодвол тэр нь энэ сонирхоод байгаа хэл чинь байсан байж магадгүй гэж байв [2]. Хамнигадын өөр зуурын харилцаандаа ашигладаг байсан эвенг хэлийг нь судлаачид олж тогтоогоод нэрлэсэн нь биш харин тэд өөрсдөө “жинхэнэ хамниган хэл” маань онцолж зааж байснаас үзэхүл Монголын хамнигад өөрсдийгөө “эвенг” гэж тодорхойлдог байсан гэж үзэж болох үндэстэй. Хэл шинжлэлчдийн дүгнэснээр Монголын хамниганы эвенг хэл нь Алтай язгуурын манж-гүнжүүсийн төрөл хэлний умардын бүлэгт багтаж, зарим үгийг харьцуулан үзэхүл Хар мөрний чигийн бүлгүүдтэй холбогдож байна.

Энд Б. Ринчен абугайн тэмдэглэж үлдээсэн монгол хамниганы эвенг хэлний үг, ярианы зүйл ба түүний утга агуулгыг нь эвенг хэлний толь бичгийн үгтэй харьцуулж гаргав. Хэдийгээр монгол хамниганы хуучны цаг тоолол уламжлагдаж үлдсэнгүй боловч тэдний үгийн сан дахь дөрвөн улирлыг нэрлэх үг нь зүүн Сибирийн манж-гүнжүүс хэлт ард түмнүүдийнхтэй адил байгаа нь манай улсын хамниганы цаг тоолол нь тэднийхтэй адил байсан байжээ гэж үзэж болохоор байна.

мон. эвенг [3]	Солон [4]	Негидал [5]	нанай/гольд/ [5]	Үльч [5]	Эвенг [4]	утга нь
Туге	тугу	Tuγani	Tuə	tuə	тугэнү	Өвөл
Нэлки	нэлхи	Nəlkə				Хавар
Боло	bolə	Boloni	Bolo	Bolo	Bolo	Намар
Джугани	дюга	zuγani	зуа	зуа	дюганү	зун

¹ Хар мөрөн өгсөөд, Сунгари мөрөн дагуу суудагна(най), орочи, самагир, үдэ-ийн хэлийг манж-гүнжүүс хэлний өмнөдийн бүлэг гэдэг.

Мон. Эвенг [З]	Манж	Орочон	Манегр, бирар ¹	Ононы хамниган ²	Утга
абен., [Б.Р]	Аwун	Авун	аун	Малагай	Малгай
герки.,[Б.Р]	Нөрki	Эрки	Эрки	үмүдү(н)	Өмд
дэкэл., [Б.Р]	-	-	Дэкэли		Ууж
Коколда	-	-	Коколло	бөөлэй, бээлэй	Бээлэй
Омал	Буһө	-	Умул	бүсэ, бүһэ	Бүс
Сун	нилусун	Асисун	Шун	дэгэл, дээл	Дээл

Монгол хамниганы эвенг хэлний ярианы зүйл хавсаргасныг мөн хэвээр буулгав:

А. Монголын хамниганы эвенг хэлээр: В. Монгол хэлэн дэх утга нь:

- | | |
|----------------------------|---|
| - Мөндө? | - Та мэнд үү? |
| - Су мөндө | - Та мэнд ээ |
| - Джа, аяа бисинди? | - За, сайн байна уу, та? |
| - Аяа, аяа! | - Сайн, сайн |
| - Джа эма сонин бисинбе? | - За ямар сонин байна вэ?
за сонин юу байна/
- Ямар ч сонин үгүй. |
| - Эма сонин ашин. | - Хэн нэртэй вэ, чи? |
| - Ни гербичи бисинде? | - Танай нэр хэн бэ? |
| - Сунгни герби нибө? | - Би Цагаан-Овоод байдагав. |
| - Би Чагань овбоду бинкев. | |

Өнөөгийн Монголын хамнигад эвенг хэлээрээ харилцах нь мартагдаж гээгдсэн боловч тэдний үг ярианд эвенг хэлний цөөн үг хадгалагдаж байна.

XX зууны эхээр дорнод Монголын нутагт ирж суусан хамнигад ямаан тэрэг дархалдгаараа зартай байжээ. Тэр ямаан тэрэгний хигээсийг нь мөөрөнд суулгахдаа зай завсар гарч холхихоос сэргийлэн шаантаг зоож бөхөлдөг. Шаантаг зоохдоо мөөрний нүхийг “аталга”-аар хэлбэж тэлнэ. Аталга гэх нь аталга-мй –гаргах, сугалах, сугалж авах гэх утгатай [4] эвенг үгнээс үүдэлтэй. Аталга- д залгасан “мй” нь үйл үг үүсгэж байгаа дагавар. Энэ үгийг одоо ч Хэнтийн хамниган хүн үг яриандаа дурдаж байна.

¹ Монголжсон түнгүүс гэгддэг.

² Нэрний тайлбаруудыг “Хамниганско-русский словарь” [Д. Г. Дамдинов, Е. В. Сундуева. Иркутск, 2015] бүтээлээс авлаа.

Манж-түнгүүс хэлний үгс Монголын хамниганы дунд хадгалагдсан нь ан авын зүйлд тусгалаа олжээ. Хамниган анчид ой хөвчид хоноглох үедээ том түүдэг асаан түүнийгээ тойрон унтацгаах бөгөөд даарч жиндэхгүйн тулд биеийн дор өвс, холтос, шоргоолжны бут болон тохмоо дэвсэж хажуулна. Дулаан хонохын тулд асаасан тэр том түүдгээ Монголын хамнигад “гулбуун” [8, с. 106] гэж нэрлэнэ. “Гулбуун” нь Сибирийн ард түмнүүдийн дунд дараах утгаар түгээмэл тархсан байдаг. “Гуливи” (енисейд)~” гуливэн” (Эрхүүд)~” гулуви” (Аян, Ербогачинд) гэх бөгөөд үгийн утга нь “ой, хээр гадаа хоноглох газар”, “ойд буудаллаж хоноглосон газар” гэсэн утгатай ажээ. Үгийн үндэс “гул” нь – гал гялсхийх, цахилгаан цахих, гал асаах, ноцоох, гал хугтах гэсэн утгыг илэрхийлнэ [6]. Судлаач А. Е. Аникин гулубуны язгуур “гул” гэх нэрийг худам монгол бичгийн хэлний “yolumta” (гал голомт) гэдэгтэй холбосон байдаг. Мөн Г. М. Василевичийн бүтээлд [4] ч гэсэн “гул” гэхийг монгол хэлний гал гэхтэй адилтгасан байна.

Бас өнөөгийн хамниган анчдын дунд ой хөвчид хоноглохдоо дайдын элдэв зэтгэр хий юм, ан амьтны дайралтаас хамгаална гэж 2-3 м урттай нойтон сургаагний үзүүрийг галд барьж цогшуулж маш хурц үзүүртэй талайбун~(талезбун [8, с. 271]) бэлдэж тавьдаг домын шинжтэй ёс уламжлагджээ. Талайбун нь гулубунтай адил Сибирт өргөн тархсан нэршил. Эвенг хэлний “таливи” нь үйс, холтос, бамбар гэсэн үг, үгийн үндэс талит~(талич~talūt) talūч нь “загас гэрдэх” гэсэн утгатай. Энэхүү талит~(талич~talūt) talūч нь манж-түнгүүс хэлний нэр үг үүсгэх дагавар “вун”-ны [7] -ны тусламжаар талайбун, талибун, таливи гэсэн хэдэн янз дуудлагатай утга нэг нэр болон үлджээ. Хамниган анчид л гулбуун, талайбун гэж ярьдаг, бид тэгж хэлдэггүй гэж хөрж буриадууд нь өөрсдөөсөө ялгадаг. Байгалын баруун талаас Хар мөрөн хүртэлх өргөн уудам нутагт тархсан “гулубун”, “талайбун” нь Монголын хамниганы дунд түүдэг галтай холбогдох өргөн утгыг илэрхийлсээр уламжлагдсан нь энэ. Сургаагийн үзүүрийг түүдэгт барьж шатааж цогшуулахад маш хурц үзүүртэй талайбун болдог.

Хамнигад түрийг нь даавуугаар ширж, улыг нь үхрийн түүхий арьсаар хийсэн “олооч” (мон. хам) ~ (олоочү [4]) гэх нэгэн төрлийн гутал өмсдөг байжээ. Олоочийн дотор нь үсгүй л болохоос биш хийц хэлбэрээрээ боетогтой төстэй. Олоочийг ямаа, үхрийн цавьны нимгэн арьсаар хийнэ. Буриадууд ч мөн олооч хийж өмсөх нь элбэг байжээ.

Монголын хамниганы дунд хоёр янзын хэл аялгуу хадгалагдаж ирсэний нэг нь эвенг хэл бөгөөд түүнийгээ хамнигад өөрсдөө жинхэнэ хамниган хэл гэж үздэг байжээ. Эвенг хэлээр хамниганы цөөн хэсэг нь ярьдаг байснаа эдүгээ мартагдаж орхигдоод ганц нэгхэн эвенг үг хэрэглэж байгаагаа эвенгийн хэлний холбогдолтойг, хамниганы үр хойчис нь эвенг гэж нэрлэдэг хэл байсан эсэхийг ч мэдэхгүй байна. Урьдын хамниган улс эвенг хэлээ жинхэнэ хамниган хэл маань гэж тодорхойлж байснаас үзэхүл мөн өөрсдийгөө ч эвенг гэж тодорхойлж байсан бололтой. Харин хамниганы ихэнх нь “дундад эртний монгол хэлний үлдэцтэй хамниган аялгуу” –аар ярьдаг байсан нь одоо цөөн хэсэгт нь өөр зуураа ярих төдий л хадгалагджээ. Өнөөгийн хамнигад энэхүү “дундад эртний монгол хэлний үлдэцтэй аялгуундаа” үндэслэж өөрсдийнхөө уг гарлыг монгол гэж тодорхойлж байна.

Литература

1. Мишиг Л. МАУ-ын хамниган аялгууг сурвалжилсан нь, олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. Улан-Батор, 1961. 193 т.
2. Баттуяа О. Хэнтий. Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл. Улан-Батор, 2004. С. 47.
3. Ринчен Б. МАУ-ын хамниган аялгуу. Улан-Батор, 1967. С. 56.
4. Василевич Г. М. Эвенкийско-русский словарь. М., 1958. 803 с.
5. Петрова Т. И. Времяисчисление у тунгусо-манчжурских народностей // Памяти В. Г. Богораза: сб. ст. М.; Л., 1937. С. 79–122.
6. Аникин А. Е. Развитие и взаимодействие тунгусо-маньчжурских заимствований в русских говорах Сибири. Новосибирск, 1990. С. 95.
7. Поппе Н. Материалы по солонскому якуку. М.: Изд-во Академии наук СССР. Л., 1931. С. 7.
8. Дамдинов Д. Г., Сундуева Е. В. Хамниганско-русский словарь. Иркутск, 2014. С. 106, 271.